

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР СУМЫН ЗДТГАЗРААС ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХАД БҮРДҮҮЛЭХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Үйлчилгээний төрөл	Бүрдүүлэх баримт бичиг	Үнэ тариф	Хандах мэргэжилтэн
1	Газар эзэмших, өмчлөхөд	- Иргэний үнэмлэхний хуулбар - Газар эзэмших тухай өргөдлийг батлагдсан маягтын дагуу - Газрын зураг, кадастрын зураг - Оршин сууж байгаа багийн Засаг даргын тодорхойлолт	Гэрчилгээний үнэ 3000 Тэмдэгтийн хураамж-6000 Газрын төлбөр/гэрээний дагуу/ Хувийн хэргийн үнэ-8430 Кадастрын үнэ-2500	Газрын даамал Э.Оюун-Эрдэнэ 95750047
2	Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах	- Газар эзэмших эрхийн гэрчилгээ - газрын төлбөрийг төлсөн тухай баримт - байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр гарсан дүгнэлтийг хэрэгжүүлсэн талаархи тодорхойлолт. Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацаа сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргана. 37.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хугацаа сунгуулах тухай хүсэлтийг хүлээн авснаас	Газрын төлбөр/гэрээний дагуу/	Газрын даамал Э.Оюун-Эрдэнэ 95750047

		хойш 15 хоногийн дотор эрхийн гэрчилгээ эзэмших нөхцөлийг хангаж ажилласан эсэхийг хянаж, түүнийг хангасан тохиолдолд газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын алба бүртгэнэ.		
3	Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх	• нотариатчаар гэрчлүүлсэн гэрээ • эрхийн гэрчилгээг шилжүүлэн авч байгаа этгээд нь уг эрхийн гэрчилгээг шилжүүлэн авснаар үүсэх эрх, үүргийг бүрэн хүлээн зөвшөөрч байгаа тухай нотолгоо • худалдан, худалдан авагч гэрээ • нас барсан бол өвлөх эрхийн гэрчилгээ • хураамж төлсөн тухай баримт. Эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор тухайн шатны Засаг дарга шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлснээр эрхийн гэрчилгээг шилжүүлсэн нь хүчин төгөлдөр болно. Газар эзэмшигч нь газар эзэмших эрхээ Иргэний хуульд нийцүүлэн барьцаалж болох бөгөөд энэ тохиолдолд сумын газрын даамал, аймаг, нийслэл, дүүргийн газрын албанд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгэнэ.	Газрын төлбөр/гэрээний дагуу/	Газрын даамал Э.Оюун-Эрдэнэ 95750047

ТАРАГТ СУМЫН ЗДТГАЗАР

